

### Аймгийн аварга малчны цомын тодорхойлолт

2020 оны 1-р сарын 10.

д/д	Үзүүлэлт	Тодорхойлолт
1	Цомын суурийн хэсэг	Цайвар ногоон чулуун хавтан дээр суурилна. Суурийн урт 30 см, өргөн 17 см-ээс доошгүй хэмжээтэй байна. Ногоон хавтанг суурийн хэсгээр 4 талаас нь гоёмсог хүрээгээр хүрээлнэ. Хүрээлсэн суурь, чулуун хавтангийн өндөр 6 см-ээс доошгүй зузаантай, доод талаасаа хаалт хийж, бэхэлсэн байна.
2	Наалт	Чулуун хавтангийн зүүн урд өнцөгт Аймгийн аварга малчин, баруун урд өнцөгт аймгийн Засаг дарга Д.Батсайхан 2020 гэсэн бичээс бүхий наалтыг байрлуулна.
3	Таван хошуу мал	Цайвар ногоон чулуун хавтан дээр 5 хошуу эцэг малын металл баримлыг эгнүүлэн байрлуулна. Эцэг малын баримлууд 4.5-6.5 см өндөртэй, 5.5-8.5 см урттай зөв харьцаатай байх ба алтан шармал өнгөтэй байна.
4	Очирваань хайрхан	Таван хошуу малын ар талаар Очирваань хайрханы дүрслэл байна. Хайрхан уул 13.5 см-ээс доошгүй өндөртэй, алтан шармал өнгөтэй, уулын оройн хэсэг мөнх цастай, мөнгөлөг өнгөтэй дүрслэгдсэн байна.
5	Захиалах тоо	Цомыг 100 ширхэгийг бэлтгэж, тохиролцсон хугацаанд хүлээлгэн өгөх ба тээвэрлэхэд гэмтэхээргүй бат бөх үзэмжтэй хайрцаг, сав баглаа боодолтой байна

Аймгийн Засаг даргын Тамгын газар

**“Аймгийн аварга малчин”-ны энгэрийн тэмдгийн  
тодорхойлолт**

2020 оны 1-р сарын 10.

Д/д	Үзүүлэлт	Тодорхойлолт
1	Үндсэн хэсэг	Аймгийн аварга малчны энгэрийн тэмдэг нь цацраг бүхий 5 хошуу хэлбэртэй, дээд талдаа зүүлтийн хэсэгтэй байна. 5 хошуу дотор дугариг давхар хүрээ хийж, цэнхэр өнгөөр суурь тавих ба хүрээний дээд хэсэгт Аймгийн аварга малчин гэсэн бичигтэй байна. Давхар хүрээний дотор Очирваань хайрханыг мөнх цасан мөнгөлөг дуулгатай, уулын энгэр хэсэг нь ногоон өнгөтэй, цэнхэр тэнгэртэй дүрсэлнэ. Уулын энгэрт 5 хошуу малын толгойг жижиг дугуй хүрээнд ялгарч танигдахуйц хэлбэрээр дүрсэлнэ.
2	Зүүлтийн хэсэг	Тэмдгийн зүүлтийн хэсэг нь шар хүрээтэй, цэнхэр дэвсгэртэй байх ба Завхан гэсэн үгийг гол хэсэгт нь товойлгон, шар өнгөөр бичсэн байна.
3	Зүүлт	Тэмдгийн зүүлт нь хувцасны энгэрт тогтооход хялбар, бат бэх, олон удаа зүүж, тайлахад эвдрэхээргүй хийгдсэн байна
4	Футляр, сав	Тэмдэгийг тус бүрт нь зориулалтын уут, эсвэл футлярт /жижиг хайрцаг/ хийнэ.
5	Үнэмлэх	“Аймгийн аварга малчин” цол, тэмдгээр шагнасныг тодорхойлох аймгийн Засаг даргын гарын үсэг, дугаар, огноо бүхий үнэмлэхийг хавсралтад үзүүлсэн загварын дагуу хэвлэж бэлтгэн хүлээлгэн өгнө.
6	Тоо, ширхэг	Энгэрийн тэмдэг 200 ш, үнэмлэх 200 ш байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газар